



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Төмөр замын дээд сургууль

Сургалтын хөтөлбөрийн нэр: Барилгын инженер

Индекс: D073202

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.Баярцэцэг

Гишүүд: Р.Болормаа

Д.Бат-Оргил

2019.05.27

Агуулга

I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт	2
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	3
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	3
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт	3
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	6
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	8
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	9
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	12
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	14
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	17
Дүгнэлт.....	19
Ерөнхий зөвлөмж.....	19
IV. Уулзалтад оролцогчдын нэрс	20
I. Багш нарын нэрс	20
II. Оюутнуудын нэрс	20
III. Ажил олгогчдын нэрс	20
IV. Төгсөгчдийн нэрс	20
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	21
VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	21
VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	21

I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Төмөр замын дээд сургууль Railway Institute of Mongolia	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Барилгын инженер /Төмөр замын барилга, зам, замын аж ахуй/	
Индекс	D073202	
Шинжээчид	<p>Шинжээчийн баг: Ахлагч: Б.Баярцэцэг /Боловсролын хүрээлэн, дээд болон мэргэжлийн боловсролын судалгааны секторын эрхлэгч, бодлогын судалгаа хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан/</p> <p>Гишүүд: Р.Болормаа /ШУТИС-ийн Барилга, архитектурын сургуулийн профессор/</p> <p>Д.Бат-Оргил / Зам Тээврийн Хөгжлийн Яамны Хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн дэд бүтэц, инноваци, нормчлол хариуцсан ахлах мэргэжилтэн /</p>	
БМИҮЗ-ийн мэргэжилтэн	Г. Даваажаргал БМИҮЗ-ийн ажлын албаны магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2019.05.07	Шинжээчид хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээн авна.
	2019.05.10	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө. Сургуульд очиж ажиллах үед тодруулах асуудлуудын жагсаалтыг гаргах.
	2019.05.13	Мэргэжилтэн сургууль дээр очиж шинжээч ажиллах бэлтгэлийг хангуулна.
	2019.05.14-15	Сургууль дээр ажиллана.
	2019.05.20	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2019.05.20	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж, санал авна.
	2019.05.21	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2019.05.22	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	2019.06.12	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчдийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн дүрэм, Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур,	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Төмөр замын дээд сургууль нь 1953 онд Төмөр замын техникум нэртэйгээр анх байгуулагдаж байжээ.

1. 1990 онд Төмөр замын сургалтын төв
2. 1993 онд Төмөр замын коллеж
3. 2004 онд Төмөр замын дээд сургууль
4. 2013 онд Тээврийн дээд сургууль
5. 2018 онд Төмөр замын дээд сургууль болж нэрээ 5 удаа өөрчилсөн байна.

2004 он хүртэл төмөр замын барилга, зам, замын аж ахуй мэргэжлийн ажилчид бэлтгэж байгаад 2004 оноос эхлэн төмөр замын барилга, зам, замын аж ахуйн инженер бэлтгэж эхэлсэн.

Хөтөлбөрийг 1993,1996, 2000, 2003, 2006, 2014, 2017, 2018 онуудад нийт 7 удаа шинэчлэн сайжруулсан.

2017 оноос эхлэн БСШУ-ны сайдын А/174 тоот тушаалаар баталсан бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагын дагуу “Барилгын инженер (Төмөр замын барилга, зам, замын аж ахуй)” хөтөлбөрийг боловсруулж, сургалтад хэрэгжүүлж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрөө боловсруулахдаа:

1. Төрөөс “Төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” -2010
2. Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн шинэчлэл хөгжлийн хөтөлбөр-2030
3. МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг судалж, хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байна.

Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг нь 80 гаруй өртөө зөрлөг бүхий 1815 км урт төмөр замтай, 15560 ажиллагчидтай ба “Төмөр замын барилга, зам, замын аж ахуй” мэргэжлээр 3100 хүн ажиллаж байна. Энэ нь бүх ажиллагсдын 20.0 орчим хувь юм. Монгол улс ойрын 10 жилд ойролцоогоор 5683.5 км төмөр зам шинээр тавих тул 9700 гаруй замын мэргэжилтэн шаардлагатай болж байгаа судалгаа хийсэн байна. УБТЗ-ын зам, замын аж ахуйн алба, нэгжийн удирдлага, инженер техникийн ажилтнуудтай хөтөлбөрийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хөтөлбөрт хийгдсэн шинэчлэл, сайжруулалтыг танилцуулж, саналыг нь авч тусгасан байна. Мөн үр дүнд суурилсан (CDIO) сургалтын дэвшилтэт арга барилд нийцүүлэх оролдлогыг хийсэн байна. Тухайлбал, сургалтыг оюутны эзэмших цогц чадамжид нийцүүлэн боловсруулсан байна.

Москва болон Эрхүү хотын Зам Харилцааны Их Сургуулийн сургалтын хөтөлбөртэй харьцуулан хөтөлбөрөө сайжруулах ажлыг Төмөр замын Дээд сургуулийн захирлын 2017 оны 66 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг гүйцэтгэсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн харьяанд сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг. Иймд ОХУ-ын туршлага, үйл ажиллагаанаас байнга суралцдаг байна.
- Москва болон Эрхүү хотын Зам харилцааны их сургуультай идэвхтэй, тогтмол хамтын ажиллагаатай байна.
- Төмөр замын барилга, зам, замын аж ахуй чиглэлээр 1953 оноос эхлэн мэргэжилтэй ажилчин бэлтгэж ирсэн арвин туршлагатай байна. Энэ туршлагадаа суурилан инженерийн хөтөлбөрөө боловсруулж, хэрэгжүүлж байна.

Анхаарах асуудал:

- Үндэсний түвшинд харьцуулсан судалгаа хийгээгүй байна. Үүнийг энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг цорын ганц сургууль хэмээн үздэгтэй нь холбоотой байна.

Зөвлөмж:

- Өөрийн орны, инженер бэлтгэдэг ижил төстэй мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн хөтөлбөртэй харьцуулсан судалгаа хийх.
- Дээд боловсролын салбарт хийгдэж байгаа өөрчлөлт шинэчлэлийг сургалтандаа нэвтрүүлэх, дэвшилттэй арга, технологиудыг авч ашиглах.
- Өндөр хөгжилтэй болон бүс нутгийн улс орнуудын ижил төстэй их, дээд сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулах, дүн шинжилгээ хийх Тухайлал, БНХАУ, АНУ, БНСУ, Япон улс гэх мэт.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

1. Төмөр замын дээд сургуулийн эрхэм зорилго, зорилт
2. Зам барилгын мэргэжилтэнд тавигдах шаардлага
3. Зам барилгын мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт зэргийг хүрэх үр дүн хэмээн үзэж хөтөлбөрийнхөө зорилгыг томъёолсон байна.

УБТЗ-ын мэргэжлийн албаны инженерүүдээр хэлэлцүүлсэн байна. 2018-2019 онуудад УБТЗ-ын Замын алба, Замын 1, 2, 3, 4, 5, 6 замын засварын машин станц, төмөр замын байгууллагуудын ерөнхий болон сургалтын инженер, хүний нөөцийн мэргэжилтнүүдээр хэлэлцүүлсэн. **3 түвшинд 3 удаагийн** хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Хэлэлцүүлгийн тэмдэглэлтэй сургуульд очиж ажиллахдаа танилцаж, баталгаажуулсан болно. Төгсөгчдийн мэдлэг, ур чадвар хөтөлбөрийн зорилгод тавигдсан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар 2017 онд ажил олгогчдын дунд санал асуулга явуулсан байна. Уг судалгаагаар 44.4 хувь нь дунд зэрэг гэсэн үнэлгээ өгсөн байна. Судалгааны тайлантай танилцаж, баталгаажуулав. Салбарын онцлогийг харгалзан эрэгтэй оюутны элсэлтийг 80.0 хувь хүргэх санал гаргасан байна.

Мэргэжилтний загварыг 4 чиглэлийн 17 үзүүлэлтээр харуулсан байна. ТЗДС-ийг 2030 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний зорилтыг 6 чиглэлээр тодорхойлсон байна.

Хөтөлбөрийн агуулгыг МИИТ, ИРГУПС-тэй дүйцүүлэн 7 удаа шинэчилсэн байна. Сүүлийн 3 жилд жил тутам 1-2 удаа УБТЗ ХНН-ийн мэргэжлийн алба, зөвлөлөөр хэлэлцүүлж хэвшсэн байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ажил олгогчдын ихэнх нь тухайн хөтөлбөрөөр Төмөр замын Дээд сургуулийг төгссөн хүмүүс байна. Иймд сургуулийнхаа багш нартай байнгын холбоотой ажилладаг байна.
- “Зуны отряд” нь ирээдүйн ажлынхаа байранд зуны 3 сарын турш ажиллаж, туршлага хуримтлуулдаг байна.

Анхаарах асуудал:

- ОХУ-ын ДБСБ-ын жишгээр 5 жилийн сургалттай болох тохиолдолд барилгын үндсэн

мэргэжлийн хичээлүүдийг нэмэх шаардлагатай. Үүнд бас ОХУ ДБСБ-ын хичээл 7 хоногт 6 хоног хичээллэдэг учраас жилд 288 цаг илүү хичээллэдэг онцлогийг хөтөлбөр боловсруулахдаа харгалзан үзэх хэрэгтэй.

Зөвлөмж:

- Сонирхогч тал, ажил олгогч, оюутны сэтгэл ханамжийн судалгаа, багш ажилтны судалгааг тогтмолжуулж, хэвшүүлэх.
- Сэтгэл ханамжийн судалгааны арга зүйг боловсронгуй болгох.
- Судалгааны программуудыг ашиглах.
- Судалгааны үр дүнг ашигладаг байх.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

ТЗДС-ын Барилгын инженер (Төмөр замын барилга, зам, замын аж ахуй) мэргэжлийн хөтөлбөрийн баг ОХУ-ын Москва, Эрхүү хотын ЗХИС-ийн Замын тэнхимтэй хамтран ажилладаг. Хөтөлбөрүүдэд шинжилгээ хийж, тогтмол шинэчлэн сайжруулдаг байна. Тухайлбал, 2017-2018 оны хичээлийн жилд Төмөр замын бүтэц хичээлийн хөтөлбөрт харьцуулсан шинжилгээ хийсэн. Харьцуулсан шинжилгээндээ үндэслэн тодорхой өөрчлөлтүүдийг хийсэн байна. Харьцуулалтыг суралцах хугацаа, сургалтын төлөвлөгөөний бүтэц, ном сурах бичгийн хүрэлцээ, хангамж, оюутанд чиглэсэн зөвлөн туслах үйлчилгээ, оюутны сургалтын ахиц амжилтыг баталгаажуулах, оюутныг хөгжүүлэх үйл ажиллагаа гэсэн 10 үзүүлэлтээр хийсэн байна.

Сургалтын төлөвлөгөө нь ерөнхий суурь хэсэгт заавал суралцах хичээл-32 багц цаг, сонгон суралцах хичээл-5 багц цаг байна. Мэргэжлийн суурь хэсэгт заавал суралцах хичээл -26 багц цаг, сонгон суралцах хичээл -4 багц цаг байна. Мэргэжлийн хэсэгт заавал суралцах хичээл-47 багц цаг, сонгон суралцах хичээл-4 багц цаг байна. Дадлага-6 багц цаг. Төгсөлтийн ажил -5 багц цаг байна. Нийт 129 багц цаг цуглуулахаар төлөвлөсөн байна.

Сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын холбоосыг схемээр харуулсан байна. (Өөрийн үнэлгээний тайлан хуудас 8)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын төлөвлөгөөг ОХУ-ын Эрхүү болон Москва хотын ЗХИС-тай харьцуулж, дүгнэлт гаргасан байна.
- Сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын холбоосыг схемээр харуулсан байна.

Анхаарах асуудал:

- ОХУ-ын Эрхүү болон Москва хотын ЗХИС-тай харьцуулахад судлах цагийн болон суралцах хугацаа өөр өөр байна. Үүний шийдлийг хэрхэн төсөөлж байна.

Зөвлөмж:

- Дээд боловсролын суурь хичээлийн цагийг багасгаж, мэргэжлийн хичээлийн цагийг нэмэх саналтай байгаагаа өөрийн үнэлгээний тайланд тусгасан байна. Дээд боловсролын суурь хичээлүүдийн цагийг багасгахгүйгээр байгалийн ухааны суурь болон эдийн засгийн онол зэрэг хичээлүүдийн агуулгыг мэргэжлийн хичээлүүдийн агуулгатай уялдуулах, нэгтгэх, шинэчлэх, сайжруулах

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг ОХУ-ын Москвагийн Тээврийн их сургууль болон Эрхүү хотын Зам Харилцааны дээд сургуулийн хөтөлбөр, төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан байна. Дээд боловсролын суурь хичээлийн багцаас бусад багцуудын хувь харьцаа эдгээр сургуулиудтай ойролцоо байна. ШУТИС-ийн барилгын инженерийн мэргэжлийн сургалтын төлөвлөгөөтэй харьцуулан дүгнэхэд дээд боловсролын суурь хичээлийн багц 90.0, мэргэжлийн суурь хичээлийн багц 70.0 орчим нийцэж байна. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөн дэх сургалтын агуулга нь төмөр замын барилгын инженерийн чиглэлээр эзэмшвэл зохих онол практикийн цогц чадварыг олгох боломжтой, давхардал багатай, харилцан уялдаатай боловсруулагдан хэрэгжиж байна. Үнэлгээний тайлангийн Зураг 2.1-д үзүүлсэн хичээл хоорондын уялдаа холбоо нь зөв харилцан хамааралтай, оюутнууд хичээлээ сонгох боломжтой, өмнөх хичээлийн мэдлэг дээр суурилан хөгжих бололцоотой, логик хамааралтай байна.

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага

- Төмөр замын дээд сургуулийн Барилгын инженерийн хөтөлбөр нь төмөр замын барилгын инженерийн чиглэлд мэргэшсэн онцлогтой хөтөлбөр байна.

Анхаарах асуудал:

Байхгүй.

Зөвлөмж:

- Мэргэжлийн суурь болон мэргэжлийн багц хичээлд бетон судлал, металл судлал хичээлүүдийг нэмж оруулах, мөн хөрсний механик, барилгын материал зэрэг хичээлүүдэд лабораторийн хичээл суулгаж өгөх;
- Мэргэжлийн хичээлд барилгын инженерийн болон төмөр замын мэргэжлийн зураг төсөл, тооцооны программыг заах, эзэмшүүлэх хичээлүүдийг судлан оруулах талаар цаашид анхаарах хэрэгтэй.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

Мэргэжлийн /Д.Оюунцэцэг, Ж.Буян-Амар, Л.Энхтуяа, Т.Алтанзул/ 4 багшийн 2-3 хичээлийн лекц, семинарын материал, оюутны бие даалтын ажлуудтай танилцахад сургалтын арга зүйг шинэчлэн зарим нэг хичээлд CDIO-ийн арга зүйг нэвтрүүлж эхэлж байна. Мэргэжлийн хичээлийн хувьд, онолын зохих мэдлэгээс гадна практик, семинарын хичээлд УБТЗ ХХК-ний практик туршлага, бодит амьдрал дээр гарч буй асуудал, шийдвэрлэж байгаа хувилбар шийдлийг таниулах, ойлгуулахад чиглэсэн сэдвүүд орж байна. Үнэлгээний тайланд дурдсан сургалтын аргуудаас жишээнд суурилсан арга, төсөлд суурилсан арга, түүхэнд суурилсан арга болон туршилтанд суурилсан аргуудыг мэргэжлийн хичээлүүд дээр түлхүү хэрэглэж байна.

Сургалтын арга зүй нь оюутнуудад багийн болон хамтын ажиллагааг хөгжүүлэх, хэлэлцүүлэг хийх, харьцуулан дүгнэх чадварыг түлхүү хөгжүүлэхээр боловсруулагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төмөр замын багц дүрэм, Төмөр замын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй гэсэн аюулгүй ажиллагааны чиглэлийн хичээлүүд ордог нь онцлог юм. Үүний үр дүнд төгсөгчид хөдөлмөр хамгааллын зохих мэдлэг чадвар эзэмшиж төгсдөг байна.

Анхаарах асуудал:

- Инженерийн геологи, Хөрсний механик гэсэн хичээлүүдэд лабораторийн цаг оруулах;
- Хуучин сургалтын хөтөлбөрт байсан Замын аж ахуйн менежмент, төлөвлөлт, эдийн засаг, Зам харилцааны эдийн засаг гэсэн хичээлүүд хасагдсанаар мэргэжлийн болон салбарын эдийн засгийн мэдлэг чадвар олгох боломжгүй болсон байна. Үүнийг анхааралдаа авч сонгон суралцах хичээлд нэмэх боломжийг судлах;

Зөвлөмж:

- Төмөр замын хайгуул төслөлт, Замын дээд тогтолцоо, Замын доод тогтолцоо зэрэг хичээлүүдэд орчин үеийн зураг төсөл, тооцооны программын сэдэв нэмж оруулан оюутнуудад энэ төрлийн программ дээр ажиллах мэдлэг чадвар эзэмшүүлэх.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

2018 онд ТЗДС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмыг шинэчлэн баталсан ба түүнд оюутны чадамжийг үнэлэх журмыг тусгасан. Үүнд оюутны онолын мэдлэг, ур чадвар, хувь хүний хөгжлийг үнэлэх аргууд оржээ. Үнэлгээний 100 оноо, ирц, идэвх, сорил 1, сорил 2, явцын бие даалт, шалгалт хэсгүүдээс бүрдэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Байхгүй.

Анхаарах асуудал:

- Оюутны мэдлэг чадварын ахиц бууралтад дүн шинжилгээ хийн ажиллах, шалгалтыг тестээс гадна өөр бусад хэлбэрийг /бичгээр, ярилцлага хийх г.м./ нэвтрүүлэхэд анхаарах;

Зөвлөмж:

- Багш нарын шалгалтын тестийн материалтай танилцахад ихэнх шалгалтын асуулт эгэл /энгийн/ тодорхойлолт, төрөл ангиллын талаарх мэдлэг шалгахад чиглэсэн, зарим нэг хичээлүүдийн асуултууд давхардсан байсан тул шалгалтын материалыг үзлэг шалгалт, шүүлт хийх, чанаржуулах, CDIO-ийн арга зүйг нэвтрүүлэхэд анхаарч ажиллахыг зөвлөж байна.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

Барилгын эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах чиглэлээр УБТЗ ХНН-ийн Хяналтын албанаас жилд 2 удаа үзлэг хийж, ажлын дэвтэрт тэмдэглэл хийж, гарсан зөрчлийг арилгуулдаг. Сүүлийн 5 жилд “Сайн” үнэлгээ авсан байна. Хичээлийн анги, танхим, лаборатори, сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгслийн хүрэлцээ хангамж орчин нөхцөлийн талаар сэтгэл ханамжийн судалгаа авч шинэчлэн сайжруулалт хийдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лабораториудыг оюутнууд өөрсдөө ээлжээр цэвэрлэж ариун цэвэр байдлыг тогтмол хангахаас гадна жилд 2 удаа УБТЗ ХНН-ийн Замын даргын үзлэгээр бүх анги танхим, лабораториор орж өөрчлөлт, шинэчлэлтийг шалгадаг байна.

Анхаарах асуудал:

Байхгүй.

Зөвлөмж:

Байхгүй.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн багийн сургалтад ашигладаг программ хангамж, компьютерийн жагсаалтыг дурдсан байна. Сэтгэл ханамжийн судалгааг 2013-2017 онд суралцагчдаас авсан. Сургалтын ажлыг зохион байгуулах талаар семинарын ажлын удирдамж, бие даалт гүйцэтгэх удирдамж, курсийн төслийн аргачлал байна. Сургалтад ашигладаг 71 төрлийн CD байна. Мэргэжлийн ном, курсийн төслийн аргачлалын номууд орос хэлээр, мөн тэдгээрээс орчуулж ашиглаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

Мэргэжлийн ном, курсийн төслийн аргачлалын номууд орос хэлээр байдаг учраас хичээлийн явцад багш нар синхрон орчуулга хийдэг давуу тал байна.

Анхаарах асуудал:

Байхгүй.

Зөвлөмж:

- Инженерийн тест боловсруулах талаар багш нарт сургалт авах.
- Конспект, семинараа орчин үеийн түвшинд хүргэж төмөр замын тооцоолол хийх сургалтын болон лицензтэй программ хангамжтай болох.
- Төмөр замын тооцоолол хийх сургалтын болон лицензтэй программ хангамжуудыг багш, оюутнууд ижил түвшинд ашиглаж сурах.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Үндсэн сурах бичиг, суурь хичээл, мэргэжлийн суурь хичээл, мэргэжлийн хичээлийн 161 ном, сэтгүүлийн жагсаалт байна. Тэдгээрийн ихэнх нь орос хэл дээр байна. Жил тутам 1-7

сая төгрөг номын баяжуулалтад төлөвлөн зарцуулдаг. 2017 оноос номын сангийн E-Library цогц программ хангамж нэвтрүүлсэн. Сэтгэл ханамжийн судалгаа авсан нотолгоо байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Ном баяжуулалт санхүүгийн хэлбэлзэлгүй тогтмол явагддаг давуу тал байна. Сургалтын орчин, сургалтын хэрэглэгдэхүүн, номын сан мэдээллийн эх үүсвэрийн шалгуурыг бүрэн хангасан гэж үзэж байна. Сургалтын орчин, сургалтын хэрэглэгдэхүүн, номын сан мэдээллийн эх үүсвэрийг тогтмол сайжруулдаг. Тухайлбал, сургалтын полигоныг УБТЗ ХНН-ийн зардлаар тохижуулж өгснөөс гадна жил бүр сайжруулах төлөвлөгөө гаргаж УБТЗ ХНН-ийн Замын алба нь Замын ангиудад хийх ажил, авах тоног төхөөрөмж, материалыг хуваарилан өгдөг давуу талтай байна.

Анхаарах асуудал:

Сургалтад шаардлагатай ном, программ хангамж авах шаардлага тулгарах үед УБТЗ ХНН-ээс санхүүжилтийн зөвшөөрөл авах үед хүндрэл үүсдэг сул тал байна. Үүнийг эртнээс буюу 2-3 жилийн өмнөөс төлөвлөж УБТЗ ХНН-ийн удирдлагад танилцуулж шийдэрлүүлэх, шаардлагатай үед төрийн болон орон нутгийн өмч худалдан авах тендер зарлуулан гүйцэтгэх.

Зөвлөмж:

- Мэргэжлийн хичээлийн англи хэлний номоор ойрын жилүүдэд баяжуулалт хийх.
- 2+3 хөтөлбөрөөр Иргупс-ийн нээлттэй номын санд холбогдон ажиллах боломж нээх.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн 2017 онд хийсэн сайжруулалтыг тус сургуулийн захирлын А/66 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг зохион байгуулсан байна.

ШУТИС-ийн нээлттэй сургуулийн “E cloud Unimis” программыг:

1. Сургалтын үйл ажиллагааг удирдах
2. Сургалтаас бусад үйл ажиллагааг зохицуулах
3. Гадаад орчинтой холбох чиглэлээр тогтмол ашиглаж байна.

Мөн хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, хөгжилтөд шаардагдах мэдээллээр удирдлага болон хөтөлбөрийн багийг ханган ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “E cloud Unimis” программыг шууд авч хэрэгжүүлж байгаа учир цаг хугацаа хэмнэж байна.

Анхаарах асуудал:

Байхгүй.

Зөвлөмж:

- “E cloud Unimis” программыг өөрийн сургуулийн онцлогт нийцүүлэн хөгжүүлэх талаар төлөвлөн ажиллах

- Багш нар “E cloud Unimis” программыг цахим хэрэглэгдэхүүн боловсруулж, сургалтандаа ашиглах чиглэлд түлхүү хөгжүүлэх

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

ОХУ-ын Москва, Эрхүү хотын ЗХИС-тай хамтын ажиллагаатай байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлдэг багийн 3 багш “багш солилцооны хөтөлбөр”-т хамрагдсан байна.

Мөн БНХАУ-ын Бугат хотын төмөр замын коллежтэй хамтран ажиллаж байна. Багш нар мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах хүрээнд хамтран ажиллаж байна. Багш нарын бусад байгууллагатай хамтран хийсэн судалгааны ажлуудыг нэгтгэн хүснэгтээр харуулсан байна. (Өөрийн үнэлгээний тайлан 62-р хуудас)

Оюутны гадаадад сурах боломжийг бүрдүүлэх, тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах чиглэлд гадаадын их, дээд сургуулиудтай багш солилцох, хэлний төв байгуулах хамтын ажиллагаа 2018 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн бол 2019-2020 оны хичээлийн жилд ОХУ-ын Эрхүү хотын Зам харилцааны улсын их сургуультай 2+3 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Мэдлэг-чадвар-хариуцлага” оюутны ур чадварын тэмцээнийг уламжлан болгон зохион байгуулж байна.

Анхаарах асуудал:

Байхгүй.

Зөвлөмж:

- ОХУ, Монгол улсын хамтарсан 2+3 хөтөлбөрөөр, ШУТИС-ийн барилгын материал, бүтээц, архитектурын сургуультай багц цаг судлах боломжийг эрэлхийлэх,

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн санхүүжилт 75.0 хувь нь сургалтын төлбөр, 8.0 хувь нь өөрийн бусад орлого, 6.0 хувь нь МБС-ыг дэмжих сангийн орлого, 11.0 хувь нь УБТЗ-ын татаасын эх үүсвэрээс тус тус бүрдэж байна. Хөтөлбөрийн санхүүжилтийн 1.7 хувь нь багш, суралцагчдын хөгжилд зарцуулагддаг. 2016-2017 болон 2017-2018 оны хичээлийн жилүүдэд сургалтын төлбөр нэмэгдээгүй. 2017 онд сургалтын полигон байгуулсан ба оюутны үйлчилгээг сайжруулахтай холбоотойгоор зардлын төлөвлөгөөнд тодотгол хийж зардал өссөн байна. Мөн оюутны тоо буурсан, сургалтын төлбөрийн тариф нэмэгдээгүй тул 320 сая төгрөгний алдагдалтай ажилласан байна. 2017 оноос эхлэн багц цагийн тогтолцоонд шилжсэн байна. Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв хийсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн оюутны хөгжил, үйлчилгээнд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлж, оюутны хөгжил, үйлчилгээний нэгж хэсэг байгуулан ажиллаж байна. Хөтөлбөрийн санхүүжилтээс оюутны хөгжилд 2018 онд 1.1 хувийг зарцуулсан бол 2019 онд 2.5 хувийг зарцуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

- Санхүүгийн шийдвэр гаргах эрх УБТЗ ХНН-ийн Ерөнхий Хорооны эрх үүрэгт байдаг байна. ТЗДС нь УБТЗ ХНН-ийн бүтэц дэх аж ахуйн нэгжийн хувьд төмөр замын тээврийн орлогоос татаас авдаг нь аливаа санхүүгийн хүндрэлд ордоггүй сайн талтай боловч өнөөгийн санхүүгийн системийн хувьд бие даан хөгжих боломж хязгаарагдмал байна.

Анхаарах асуудал:

Байхгүй.

Зөвлөмж:

Байхгүй.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

УБТЗ-ын Хүний нөөцийн алба галт тэрэгний бусад хөдөлгөөнтэй холбоотой мэргэжлийн алба, салбар, нэгжээс ирүүлсэн тухайн мэргэжлийн элсэлтийн хяналтын тоо, тус албанаас гаргасан судалгаанд үндэслэн элсэлтийн хяналтын тооны санал нэгтгэгдэж, замын удирдлагад танилцуулан баталгаажуулдаг байна. Элсэлтийн хяналтын тоог жил бүрийн эхний 4 сарын дотор гаргаж хэвшсэн байна.

Элсэлтийн үйл ажиллагааг УБТЗ-ын Хүний нөөцийн албатай хамтран 7 газар цэгт зохион байгуулдаг. Элсэлт сурталчлах ажлыг жил бүрийн 1-р улиралд хийдэг байна. УБТЗ-ын санхүүжилтээр хөтөлбөрөө сурталчлах, хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Байхгүй.

Анхаарах асуудал:

Байхгүй.

Зөвлөмж: Идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

Сургууль болон сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг сургуулийн цахим хуудас www.instrans.mn болон албан ёсны нүүр хуудас [https://www.facebook.com/Төмөр - Замын-Дээд-Сургууль-Албан -ёсны -хуудас-275309012634700/](https://www.facebook.com/Төмөр-Замын-Дээд-Сургууль-Албан-ёсны-хуудас-275309012634700/) тогтмол ажиллаж байна.

“Оюутан танд зөвлөж байна” гарын авлага хөтөлбөр бүрээр гадаг. “Ажил олгогч-Төгсөгчид”, “Мэргэжлийн өдөрлөг” зохион байгуулдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Харьцангуй хаалттай сургууль байсан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн сурталчилгааг өргөн хүрээг хамарсан, олон нийтийн сонирхлыг татахуйц байдлаар зохион байгуулах талаар идэвх санаачилгатай ажиллах байдал сул байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрөө олон нийтэд сурталчлах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан ажиллах, Сурталчилгааны сонирхолтой хэлбэрүүдийг ашиглах, цахим сайтын үйл ажиллагааг тогтмолжуулах.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Элсэлтийн үйл ажиллагааг хүчин төгөлдөр байгаа хууль тогтоомжийн дагуу Улаанбаатар хот болон тулгуур 5 өртөө, Дорнод аймагт МИДСК-ийн элсэлтийн хугацаатай давхцуулан зохион байгуулдаг. Элсэлтийн комисс ажиллаагүй бусад аймгаас элсэх үед элсэлт авч байгаа хамгийн ойрын аймагт өөрийн биеээр эсвэл тус сургуулийн elselt.insttrans.mn хаягаар бүртгүүлж оролцдог. Үүнээс гадна УБТЗ ХНН-ийн төв эмнэлгийн эрүүл мэндийн үзлэгээр тэнцсэн тохиолдолд суралцах эрх үүсдэг юм байна. Элсэгчдийн ЕШ-ын босго оноо математикаар 480, физикээр 400 байна. Хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцааг тусгаагүй байна. Шинээр элсэн суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага гаргаж танилцуулдаг. Гарын авлага нь сургуулийн цахим сайтад байрласан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус сургуулийн элсэлтийн журам жил тутам шинэчлэгддэг.

Анхаарах асуудал:

Байхгүй.

Зөвлөмж:

- Суралцагчдын тоог жил бүр багасгаж байгаад дүгнэлт хийж, хөтөлбөрийн сурталчилгааг үр ашигтайгаар зохион байгуулах шаардлагатай байна.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний 13 хууль, дүрэм, 13 төрлийн үйлчилгээ үзүүлдэг байна. Сэтгэл ханамжийн судалгаа, баримт нотолгоо, зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ байна. Эрдэм шинжилгээ судалгааны ажлын тайлан мэдээг ӨҮТ-ийн 51-р хуудас 4.2.1 хүснэгтээр харуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- УБТЗ ХНН-ийн хүний нөөцийн алба элсэх оюутны тоо, хүйсийн харьцааг баталдаг байна.

Анхаарах асуудал:

- Ажил олгогч буюу Замын ангийн удирдлагууд хүйсийн харьцааг 80% эрэгтэй, 20% эмэгтэй байвал зүйтэй гэж санал гаргасныг харгалзан үзэх.

Зөвлөмж:

- Төмөр замын талаар анхан шатны ойлголтууд, төмөр замаар нэвтрэн өнгөрөх үеийн аюулгүй ажиллагааны талаар мэдлэггүй элссэн оюутанд тусгайлан сургалт явуулж тэдний аюулгүй байдалд анхаарах.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

Оюутны клубийн зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээг 5.1.4 хүснэгтээр харуулсан байна. Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшууллын нотолгоо жишээ дурдсан байна. Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл 2014-2018 онуудад өссөн дүнгээр 25 хүн байна. Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүн, урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоон мэдээллийг ӨҮТ-ийн 5.1.3 хүснэгтээр харуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн жилүүдэд мэргэжил тус бүрээр оюутны отряд ажиллуулж оюутнуудад ажлын хөлс олгож, кредитийн төлбөрийн урамшуулал олгож байгаа давуу тал байна.
- Оюутан орос хэлний шалгалт өгсөн тохиолдолд ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путиний тэтгэлгээр Иргупс-т элсэн суралцах боломжтой.

Анхаарах асуудал:

- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоо нэлээд цөөн байгааг цаашид өсгөх арга хэмжээ зохион байгуулах.
- Цаашид англи хэлний сургалт, нисэх загвар зэрэг секц дугуйланд сайн дураар хамрагдсан оюутанд зохих урамшуулал олгох нь зүйтэй.

Зөвлөмж:

- Ажиллагчдын төлөөлөл буюу төгсөгчид энэ хөтөлбөрөөр эзэмших мэргэжлийг төрөлх хэлээрээ сурч төгсөх нь давуу талтай гэсэн санал гаргасныг анхаарч Иргупс-тэй хамтран 2+3 хөтөлбөр хэрэгжүүлэх нь туйлын зөв санаачилга байна. Заавал хэрэгжүүлэх шаардлагатай.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа, багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний дүрэм журмыг хүснэгт 5.4.1-д дурдсан байна. ТЗДС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөр хооронд мэргэжлийн чиглэл солих асуудлыг ТЗДС-ийн захрилын 2018 оны А-190 дугаар тушаалаар шийдвэрлэдэг байна. 2018-2019 оны хичээлийн жилд 10 оюутан шилжилт хөдөлгөөнд орсноос жилийн чөлөө авсан 6, Хагас жилийн чөлөө авсан 2, жилийн чөлөөнөөс ирсэн 1, гадаадаас шилжин ирсэн 1 оюутан байна.

Суралцагч сонгох, элсүүлэх, хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлэх, суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо, суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажиллах, суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдаж байна.

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан олон улсын түвшинд байна гэж үзэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шилжилт хөдөлгөөнд хамрагдсан байдлаас хөтөлбөр хооронд шууд дүйцүүлэхээр, гадаадын их дээд сургуулиас шилжин ирэх тохиолдолд тухайн сургуулийн магадлан итгэмжлэгдсэн байдлаас хамаарч дүйцүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.

Анхаарах асуудал:

Байхгүй.

Зөвлөмж:

- Төмөр замын шинэ бэхэлгээ, шинэ стандартуудыг оюутнуудад зааж өгөх хэрэгтэй.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

Төгсөлтийн үндсэн баримт бичиг нь бакалаврын диплом бөгөөд эзэмшсэн мэргэжлийн нэр, суралцсан бүх хичээл, дадлага, улсын шалгалтын үнэлгээ, голч оноо, дипломын сэдвийн нэр гэсэн үндсэн мэдээллүүд агуулагддаг. Үүнээс гадна бүх төгсөгчдөд УБТЗ ХНН-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тусгай сургалтад хамрагдсан гэрчилгээ олгодог давуу тал байна. Төгсөлтийн баримт бичгийг БСШУЯ-ны “Дээд боловсролын диплом олгох журам”-ын дагуу олгодог байна. Ажил олгогч талын хүсэлтээр зөвлөх багшаас тухайн оюутны зан байдал, спорт, урлагийн авьяас чадвар, судалгаа шинжилгээний ажил, сайн дурын ажил, нийгмийн идэвх, зэргийг тодорхойлж өгдөг давуу тал байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шилдэг оюутнуудыг ажлын байранд шууд авдаг туршлага байна.

Анхаарах асуудал:

- Байхгүй.

Зөвлөмж:

- Ажил олгогч төгсөгчдөд ажил үүрэг өгч ажиллуулах үедээ тэдний идэвх зүтгэл, санаачилга, мэдлэг чадварыг тодорхой хугацаанд ажиглаж ажил гүйцэтгэх, итгэл даах чадах, тэвчээртэй, ажлын ачаалал даадаг, өөрөө өөрийгөө хөгжүүлэхэд анхаардаг хүмүүсийг бэлтгэх саналтай байгааг харгалзан хөтөлбөрөө цаашид хөгжүүлэх шаардлагатай байна.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна. Зөвлөн туслах үйлчилгээ.

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

Багшийн хөгжлийн хөтөлбөр боловсруулан УБТЗ компанийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж багш нарын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх сургалтыг явуулсан байна.

Сургуулийн удирдлага сүүлийн 2 жилд эрдмийн зэрэг цолтой багшийн тоог нэмэгдүүлэхэд анхаарч БНСУ болон бусад сургуульд Ph.D докторын зэрэг хамгаалсан 3 багшийг багшаар авсан байна.

Тухайн хөтөлбөрт хичээл заадаг багш нарын бүрэлдэхүүн 8-аас дээш жил багшилсан, магистр зэрэгтэй, мэргэжлээрээ практик дээр ажиллаж туршлага хуримтлуулсан багш нар байна. Ялангуяа мэргэжлийн 4 багш нартай нэг бүрчлэн ярилцлага хийхэд 4 багшийн 3 нь докторантур (ОХУ-ын Эрхүүгийн Зам харилцааны их сургуульд докторант, ШУТИС-ийн докторант нар байв/ суралцдаг. Д.Оюунцэцэг багш ТЗДС-д 20 орчим жил багшилж байгаа бөгөөд ОХУ-ын Ленинградын Төмөр замын дээд сургуулийг төгсөөд мэргэжлээрээ 10 гаруй жил ажиллаж байгаад багшилж эхэлсэн байна. Ж.Буюан-Амар, Алтанзул багш нар ОХУ-ын Эрхүүгийн Зам харилцааны дээд сургуулийг төгссөн, магистр зэрэгтэй, 12-18 жил багшилж байгаа туршлагатай. Д.Энхтуяа багш ТЗДС-ийг энэ мэргэжлээр төгсөж, 10 гаруй жил тогтвор суурьшилтай багшилж байгаа юм байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын 75.0 нь ОХУ-д мэргэжил эзэмшсэнээс гадна бүгд орос хэлний мэдлэг чадвар өндөртэй байгаа нь онцлог байна.

Анхаарах асуудал:

- Байхгүй.

Зөвлөмж:

- ТЗДС-ийн удирдлагын зүгээс багш нарт эрдмийн ажлаа хийхэд нь зохих дэмжлэг үзүүлэх (туршилт судалгааны ажил хийхэд нь бусад сургууль, эрдэмтэдтэй холбож өгөх гэх мэт) тодорхой хугацаатай үүрэг даалгавар өгөх;
- Залуу багш нарыг туршлагатай багш нарт дагалдуулж сургах үйл ажиллагааг зохион байгуулалттай явуулах;

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

Тухайн хөтөлбөрийн 22 багш 2016-2019 онд гадаад дотоодын сургалт семинар, хуралд оролцон мэргэжил дээлшүүлэх, чадавхжих үйл ажиллагаанд хамрагдсан байна. Мөн ажлын байран дээр сургалт явуулах үйл ажиллагааг төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна.

ТЗДС-ийн багш нар УБТЗ ХНН-ийн захиалгаар тодорхой хэмжээний гэрээт ажил гүйцэтгэж байна. Жишээлбэл, энэ жил ЗТХЯам, УБТЗ ХНН-тэй хамтран Төмөр замын салбарын стандартууд боловсруулсан байна. Эрдэм шинжилгээний хурал семинарт илтгэл хэлэлцүүлэх болон Эрхүүгийн ЗХИС-ийн ЭШ-ний эмхэтгэлд өгүүлэл хэвлүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн удирдлага хоёр жилийн өмнөөс багшийн жилийн ачааллыг бууруулсан журам баталснаар багш нар судалгаа шинжилгээний ажилд оролцох, өөрийгөө хөгжүүлэх цаг боломжтой болсон нь их сайшаалтай байна.

Анхаарах асуудал:

Байхгүй.

Зөвлөмж:

- Барилгын инженерийн болон зам харилцааны чиглэлийн бусад сургуулийн багш нартай хамтран хурал семинар хийх, туршлага солилцох (хөрсний чиглэлээр, төмөр бетон байгууламж, металл бүтээц, механикийн чиглэл гэх мэт);
- Талбайн болон лабораторийн туршилт, судалгааны ажил гүйцэтгэхэд түлхүү анхаарах;

- Бусад их, дээд сургууль, судалгааны хүрээлэнтэй хамтран төсөл, судалгаа хэрэгжүүлж, туршлага хуваалцах;

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

ТЗДС-ийн багш нар УБТЗ ХНН-ийн захиалгаар тодорхой хэмжээний гэрээт ажил гүйцэтгэж, түүндээ оюутнуудаа хамруулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ТЗДС нь УБТЗ ХНН-ийн харьяа сургууль тул ихэнхдээ уг байгууллагын захиалгаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж байна.

Анхаарах асуудал:

- Цаашид судалгааны ажлаа өргөжүүлэхэд анхаарч ажиллах;

Зөвлөмж:

Байхгүй.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

Багшийн сургалт заах арга зүйн чиглэлээр нээлттэй хичээл семинарын төлөвлөгөөг хичээлийн жил бүр боловсруулж батлуулан хэрэгжүүлсэн байна. Нээлттэй хичээл болон багш нарын хичээлд суусан журнал хөтөлж үнэлгээ өгсөн боловч бүх багш нарын хичээл дээр зөвхөн Энхжаргал багш сууж, ерөнхий зөвлөмж үнэлгээ өгч байсан байна. Мөн тухайн зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар давтан хяналт шалгалт хийгээгүй байна.

ТЗДС-ийн Заах арга зүйн зөвлөл багш нарын хичээлийн агуулга, багтаамж, сэдвийн давхардал, хичээлд бэлдсэн байдал зэрэгт хөндлөнгийн хяналт, үзлэгийн тогтмол тавьж ажиллаагүй байна.

2014 оноос Багш нарын эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний үйл ажиллагааг үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ журам нь 5 бүлгээс бүрдсэн, эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэл, эрдэм шинжилгээний хурал семинар, Оюуны өмч, төсөл гэрээт ажил зэргийг хамарсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Байхгүй.

Анхаарах асуудал:

Байхгүй.

Зөвлөмж:

- Өөрийн үнэлгээний тайланд дээр дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлснээр гарсан ахиц, өөрчлөлтийг дүгнэсэн дүн шинжилгээ хийгээгүй, цаашид сайжруулах, анхаарч ажиллах зүйлсийг тодорхойлох;
- Багш нарын ЭШ, судалгаа, нийгмийн үйлчилгээний ажлыг үнэлэх журмыг өөрийн сургуулийн онцлогт илүү тохируулан шинэчлэх;
- Багшийн заах арга зүй, мэргэжлийн ур чадварыг бодитой үнэлэх төлөвлөгөө, журам боловсруулж ажиллах, үнэлгээ, зөвлөгөөний мөрөөр дахин шалгалт, дүн шинжилгээ хийж, цаашдын үйл ажиллагаа, зорилтоо тодорхойлдог болох;

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

ТЗДС-ийн захирлын 2018 оны А/191 тоот тушаалаар “Сургалтын чанарын дотоод баталгаажилтын баг”-ийг сургалтын дотоод хяналтын мэргэжилтнээр ахлуулан 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Мөн А/240 тоот тушаал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Байхгүй.

Анхаарах асуудал:

- 2018 оноос өмнө хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын баг ажиллаж байгаагүй. Иймд багийн гишүүдийг чадавхжуулах шаардлагатай.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллах.
- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалт хийх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, сургуулийн удирдлага, багш, оюутанд танилцуулах.
- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг төлөвшүүлэх

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварыг хөтөлбөрийн зорилго, зорилтуудтай уялдуулсан байна. Мөн хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар ба хувь хүний ур чадварын хамаарлыг хүснэгтээр харуулсан байна. Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаагаар нийт 10 чадвараас нэг л чадварыг сайн гэж үнэлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ажлын байр тодорхой. Түүнд тавигдах мэдлэг, чадвар, хандлага тодорхой байна.

Анхаарах асуудал:

Байхгүй.

Зөвлөмж:

- Сэтгэл ханамжийн судалгааны арга зүйгээ сайжруулах
- Судалгаа шинжлэх ухааны үндэслэл сайтай байх.
- Хөтөлбөрийг сонирхож байгаа иргэдийн хэрэгцээний болон ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны арга зүйг боловсронгуй болгох.
- Судлаачдыг чадавхжуулах, хөгжүүлэх.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

Төмөр замын дээд сургууль нь 2001, 2006, 2016, 2018 онд тус тус БМИҮЗ-ийн “Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэл”-д амжилттай магадлан итгэмжлэгдсэн байна.

Цаашид хөтөлбөрийн дотоодын болон олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар магадлан итгэмжлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн хөтөлбөрөө дотооддоо магадлан итгэмжлүүлж байна.

Анхаарах асуудал:

Байхгүй.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг боловсруулахад тавигдах төрийн захиргааны төв байгууллагын шаардлага, хөтөлбөрийн дотоодын болон хөндлөнгийн магадлан итгэмжлэл хийх шалгуур шаардлагатай сайтар танилцаж, хөтөлбөрийн боловсруулалтыг сайжруулах;
- Хөтөлбөр боловсруулахад тавигдах шаардлага, хэрэгжүүлэх орчин нөхцөл, хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт өгөх ажлыг системтэй хийх, сургуулийн хамтын олны оролцоог тэгш хангах;
- Хөтөлбөрийн чиглэлээр хүний нөөцөө чадавхжуулах;
- Гадаадад хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллах;

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Төмөр замын дээд сургуулийн ” Барилгын инженер” /D073202/ хөтөлбөр

Шалгуур		Бүрэн Хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа		1		
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Төмөр замын дээд сургуулийн “Барилгын инженер” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: Б.Баярцэцэг

Шинжээчийн багийн гишүүн: Р.Болормаа

Шинжээчийн багийн гишүүн: Д.Бат-Оргил

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Барилгын материал, бүтээцийн хичээл, хөрсний механик шинж чанарыг тодорхойлох лабораторийг байгуулж, лабораторид сургалт явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.
2. ОХУ, Монгол Улсын хамтарсан 2+3 хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр сургалтын төлөвлөгөөн дэх цагийн зөрүүг шийдвэрлэх.
3. ШУТИС-тай багц цаг хүлээн зөвшөөрөх боломжийг судалж, нэвтрүүлэх.

4. Багш нарын эрдэм шинжилгээ, судалгаа, ниймгийн үйлчилгээний ажлыг үнэлэх журмыг өөрийн сургуулийн онцлогт илүү тохируулан шинэчлэх;
5. Багшийн заах арга зүй, мэргэжлийн ур чадварыг бодитой үнэлэх төлөвлөгөө, журам боловсруулж ажиллах, үнэлгээ, зөвөлгөөний мөрөөр дахин шалгалт, дүн шинжилгээ хийж, цаашдын үйл ажиллагаа, зорилтоо тодорхойлдог болох;
6. Төмөр замын хайгуул төслөлт, Замын дээд тогтолцоо, Замын доод тогтолцоо зэрэг хичээлүүдэд орчин үеийн зураг төсөл, тооцооны программын сэдэв нэмж оруулан, программ дээр ажиллах мэдлэг чадвар эзэмшүүлэх;
7. Бетон судлал, металл судлал хичээлүүдийг нэмэх, хөрсний механик, барилгын материал зэрэг хичээлүүдэд лабораторийн хичээл оруулах;
8. Барилгын инженерийн болон төмөр замын мэргэжлийн зураг төсөл, тооцооны программыг эзэмшүүлэх хичээлүүдийг судлан оруулах;

ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН ШАЛГУУРТ ӨГСӨН ШААРДЛАГА:

2.2. Төмөр замын хайгуул төслөлт, Замын дээд тогтолцоо, Замын доод тогтолцоо зэрэг хичээлүүдэд орчин үеийн зураг төсөл, тооцооны программын сэдэв нэмж оруулан, программ дээр ажиллах мэдлэг чадвар эзэмшүүлэх;

2.3. Шалгалтын тестийн материалтай танилцахад ихэнх шалгалтын асуулт эгэл (энгийн) тодорхойлолт, төрөл ангиллын талаарх мэдлэг шалгахад чиглэсэн, зарим нэг хичээлийн асуултууд давхардсан байгаа тул шалгалтын материалыг үзлэг шалгалт, шүүлт хийх, чанаржуулах, CDIO-ийн арга зүйг нэвтрүүлэхэд анхаарч ажиллах;

4.5. Хөтөлбөрөө олон нийтэд сурталчлах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан ажиллах. Сурталчилгааны сонирхолтой хэлбэрүүдийг ашиглах, цахим сайтын үйл ажиллагааг тогтмолжуулах;

6.3. Багш нарын эрдэм шинжилгээ, судалгаа, нийгмийн үйлчилгээний ажлыг үнэлэх журмыг өөрийн сургуулийн онцлогт илүү тохируулан шинэчлэх;

7.1. Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллах; Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалт хийх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, сургуулийн удирдлага, багш, оюутанд танилцуулах;

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1.	Г.Золчимэг	Ахлах багш	Магистр	20	Биеийн тамир
2.	Ж.Буян-Амар	Ахлах багш	Магистр	18	ХАБЭА, Хөрсний механик, ТЗ-н хайгуул төсөл
3.	М.Энхбаяр	Ахлах багш	Магистр	20	Эдийн засаг
4.	Т.Алтанзул	Ахлах багш	Магистр	12	Хиймэл төхөөрөмж ТЗЕК

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1.	Б.Отгондалай	Замын аж ахуй П-2	Дунд сурагч
2.	Б.Энх-Амар	Замын аж ахуй П-4	Дэвшин суралцсан техникумаас
3.	А.Оюунтүлхүүр	Замын аж ахуй П-4	Шугам замын хүүхэд /Замын үүд/
4.	М.Баттулга	Замын аж ахуй П-4	Ангийн дарга /2018 оны шилдэг оюутан/
5.	Д.Отгонхишиг	Замын аж ахуй П-3	Дотуур байрны оюутан
6.	Э.Удвал	Замын аж ахуй П-3	Онц сурдаг /Оюутны отряд/
7.	Б.Жааханцэцэг	Замын аж ахуй П-3	ЭШОП-д байнга оролцдог судлаач оюутан
8.	А.Нямсүрэн	Замын аж ахуй П-3	Цэрэгт явсан /Улирсан/

9.	Г.Баасанжаргал	Замын аж ахуй П-3	Удирдагч оюутан
10.	С.Анхбаяр	Замын аж ахуй П-4	Ажиллаж байсан /Төмөр замд/
11.	О.Пүрэвбаатар	Замын аж ахуй П-4	Бүтэн өнчин /Төрийн сан/
12.	Б.Бямбасүрэн	Замын аж ахуй П-3	Малчны хүүхэд


III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1.	Ж.Борхүү	Замын алба	Орлогч дарга
2.	Д.Баярмаа	Замын алба	Сургалтын инженер
3.	Ж.Ууганбаяр	ПЧ-2	Орлогч дарга
4.	Д.Энхтулга	ПЧ-2	Ерөнхий инженер
5.	Я.Долгормаа	ПЧ-2	Хүний нөөц
6.	П.Жаргалсайхан	ПЧ-2	ҮЭ-н дарга
7.	Б.Буяндэлгэр	ЗЗМС	Хүний нөөц
8.	Д.Эрдэнэбаатар	ПЧ-4	Орлогч дарга

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1.	Н.Хишигмаа	2013	ПЧ-2	Мастер
2.	Х.Мэндсайхан	2014	ПЧ-2	Бригадын дарга
3.	М.Доржмаа	2018	ПЧ-2	Замчин
4.	С.Отгонжаргал	2014	ПЧ-4	Мастер
5.	Б.Батхүү	2014	ПЧ-4	Мастер
6.	Б.Батсайхан	2009	Болт төмөр ерөө гол	Дарга

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)

[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/